

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/084/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2025 он	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Аудитор: А.Мөнхцэцэг Утас: 70512123 Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 181

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

EDU-CLASS хөтөлбөрийн хүрээнд Мобинет ХХК 76.5 сая төгрөгийн ерөнхий гэрээг байгуулж тоног төхөөрөмж, сэлбэг, хэрэгсэл нийлүүлсэн бөгөөд төлбөрийг 2-4 жилийн хугацаанд төлж барагдуулахаар заасны дагуу тайлант онд 54.2 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайлан, тодруулгад илэрхийлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст буюу 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Боловсролын яамнаас 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг цалин хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд хуваарилсан ба мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээр тайлагнасан байна.

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.МӨНХБАТ
ТАНАА

Бусад асуудал

Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 онд түүхт 100 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Энэхүү ойг тохиолдуулан олон арга хэмжээ зохион байгуулагдсан бөгөөд үүнд баярын хурал, шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн тоглолт зэрэг үйл ажиллагаа болсон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>138,452,281.31</u>	<u>150,769,473.11</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	71,794,685.14	75,458,006.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	71,794,685.14	75,458,006.44
3121	Төгрөг	71,794,685.14	75,458,006.44
31211	Төрийн сангийн харилцах	71,794,685.14	75,458,006.44
35	БАРАА МАТЕРИАЛ	66,657,596.17	75,311,466.67
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,839,400.00	38,500.00
354	Хангамжийн материал	38,948,315.74	59,587,086.24
35410	Бичиг хэргийн материал	381,000.00	476,000.00
35420	Аж ахуйн материал	14,739,600.00	35,508,158.00
35440	Түлш, шатах тослох материал	217,800.00	495,000.00
35460	Хүнсний материал	-	90,500.00
35470	Бусад хангамжийн материал	23,609,915.74	23,017,428.24
35600	Мал амьтад	5,184,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,055,095,488.03</u>	<u>2,497,471,958.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,055,095,488.03	2,497,471,958.74
392	Биет хөрөнгө	2,019,900,488.03	2,428,985,222.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,921,210,614.86	2,029,041,667.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(234,488,686.20)	(290,873,717.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,093,749.55)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	457,526,388.54	553,502,905.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(235,109,283.97)	(113,634,869.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	146,151,924.15	219,976,382.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(102,330,531.51)	(31,107,212.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	28,432,300.00	27,002,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,426,341.97)	(10,677,638.57)
39217	Ном	39,527,853.68	45,755,403.68
393	Биет бус хөрөнгө	35,195,000.00	68,486,736.68
39301	Програм хангамж	2,250,000.00	11,637,575.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(965,000.00)	(1,980,838.32)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,910,000.00	58,830,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,193,547,769.34</u>	<u>2,648,241,431.85</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>58,262,919.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	58,262,919.43
413	Өглөг	-	58,262,919.43
4136	Бусад өглөг	-	58,262,919.43
41361	Байгууллагад төлөх өглөг	-	58,262,919.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,193,547,769.34</u>	<u>2,589,978,512.42</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,193,547,769.34	2,589,978,512.42
512	Хуримтлагдсан үр дүн	224,169,333.22	620,600,076.30
51210	Өмнөх үеийн үр дүн	(87,930,757.27)	224,169,333.22
51220	Тайлант үеийн үр дүн	312,100,090.49	396,430,743.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,193,547,769.34</u>	<u>2,648,241,431.85</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,738,670,737.64	3,988,794,662.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	306,269,037.64	517,852,162.65
120	Нийтлэг татварын бус орлого	306,269,037.64	517,852,162.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	306,269,037.64	517,852,162.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,262,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,535,000.00	14,086,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	273,858,796.34	492,733,370.15
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	19,612,541.30	11,032,792.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,432,401,700.00	3,470,942,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,329,401,700.00	3,345,942,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,329,401,700.00	3,345,942,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,000,000.00	125,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,000,000.00	125,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,426,570,647.15	3,582,894,258.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,426,570,647.15	3,582,894,258.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,285,635,924.91	3,417,893,648.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,682,398,036.92	2,555,512,611.89
210101	Үндсэн цалин	1,104,855,468.51	1,449,560,437.82
210102	Нэмэгдэл	472,088,246.92	938,585,108.94
210104	Урамшуулал	105,454,321.49	167,367,065.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,318,475.00	319,230,799.38
210201	Тэтгэврийн даатгал	143,016,123.00	217,405,600.64
210202	Тэтгэмжийн даатгал	16,825,738.00	25,387,564.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,460,390.40	12,658,732.07
210204	Ажилгүйдлийн даатгал	3,365,147.60	12,643,023.21
210205	Эрүүл мэндийн даатгал	33,651,076.00	51,135,879.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,456,821.76	108,801,796.68
210301	Гэрэл, цахилгаан	31,176,113.76	32,566,906.68
210302	Түлш, халаалт	60,474,208.00	63,303,890.00
210303	Цэвэр, бохир ус	5,806,500.00	12,931,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,532,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	2,532,000.00	-
2105	Нормативт зардал	90,209,300.00	99,134,300.00
210502	Хоол, хүнс	90,209,300.00	99,134,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,986,800.00	17,995,320.00
210604	Урсгал засвар	4,986,800.00	17,995,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,874,566.72	24,028,285.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,262,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,611,866.72	24,028,285.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,859,924.51	293,190,534.63

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,687,515.00	131,703,556.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,161,659.00	22,381,680.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,010,750.51	139,105,298.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,934,722.24	165,000,610.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,918,020.00	164,931,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,200,020.00	140,924,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,718,000.00	24,007,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,702.24	69,160.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,702.24	69,160.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>312,100,090.49</u>	<u>405,900,404.35</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,469,661.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	9,469,661.27
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(9,469,661.27)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>312,100,090.49</u>	<u>396,430,743.08</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,445,199,400.00</u>	<u>3,485,028,500.00</u>
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>12,797,700.00</u>	<u>14,086,000.00</u>
120004	Нийтлэг татварын бус орлого	12,797,700.00	14,086,000.00
1200041	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,797,700.00	14,086,000.00
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,262,700.00	-
13	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,535,000.00	14,086,000.00
1310	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,432,401,700.00</u>	<u>3,470,942,500.00</u>
131001	Улсын төвлөрсөн төсвөөс	2,329,401,700.00	3,345,942,500.00
1320	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,329,401,700.00	3,345,942,500.00
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,000,000.00	125,000,000.00
2	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,000,000.00	125,000,000.00
21	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,329,671,162.64</u>	<u>3,416,707,073.45</u>
210	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,329,671,162.64</u>	<u>3,416,707,073.45</u>
2101	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>2,181,911,040.40</u>	<u>3,258,507,363.45</u>
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,682,398,036.92	2,555,512,611.89
210102	Үндсэн цалин	1,104,855,468.51	1,449,560,437.82
210104	Нэмэгдэл	472,088,246.92	938,585,108.94
2102	Урамшуулал	105,454,321.49	167,367,065.13
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,318,475.00	319,230,799.38
210202	Тэтгэврийн даатгал	143,016,123.00	217,405,600.64
210203	Тэтгэмжийн даатгал	16,825,738.00	25,387,564.06
210204	ҮОМШӨ-ний даатгал	13,460,390.40	12,658,732.07
210205	Ажилгүйдлийн даатгал	3,365,147.60	12,643,023.21
2103	Эрүүл мэндийн даатгал	33,651,076.00	51,135,879.40
210301	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,996,497.76	104,930,840.00

210302	Гэрэл, цахилгаан	31,176,113.76	28,500,000.00
210303	Түлш, халаалт	61,013,884.00	63,499,840.00
2105	Цэвэр, бохир ус	5,806,500.00	12,931,000.00
210502	Нормативт зардал	90,063,800.00	99,224,800.00
2106	Хоол, хүнс	90,063,800.00	99,224,800.00
210604	Эд хогшил, урсгал засварын зардал	4,986,800.00	17,970,200.00
2108	Урсгал засвар	4,986,800.00	17,970,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,342,566.72	30,719,285.72
210806	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,262,700.00	-
2109	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,079,866.72	30,719,285.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,804,864.00	130,918,826.46
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	60,641,095.00	108,649,326.46
213	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,163,769.00	22,269,500.00
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,760,122.24	158,199,710.00
213205	Бусад урсгал шилжүүлэг	147,743,420.00	158,130,550.00
213209	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,025,420.00	134,123,550.00
2134	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,718,000.00	24,007,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,702.24	69,160.00
3	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,702.24	69,160.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	115,528,237.36	68,321,426.55
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,554,490.00	64,658,105.25
2200	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,554,490.00	64,658,105.25
225106	Дотоод эх үүсвэрээр	54,554,490.00	64,658,105.25
6	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,554,490.00	64,658,105.25
8	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(54,554,490.00)	(64,658,105.25)
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	60,973,747.36	3,663,321.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,820,937.78	71,794,685.14
		71,794,685.14	75,458,006.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-87,930,757.27	1,881,447,678.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-87,930,757.27	1,881,447,678.85
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	312,100,090.49	312,100,090.49
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	224,169,333.22	2,193,547,769.34
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	224,169,333.22	2,193,547,769.34

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	224,169,333.22	2,193,547,769.34
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	396,430,743.08	396,430,743.08
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	620,600,076.30	2,589,978,512.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,556,112,400.00	3,481,296,018.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,556,112,400.00	3,481,296,018.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,397,981,800.00	3,323,165,468.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,619,797,700.00	2,555,512,611.89
210101	Үндсэн цалин	1,614,423,100.00	1,449,560,437.82
210102	Нэмэгдэл	888,291,100.00	938,585,108.94
210104	Урамшуулал	117,083,500.00	167,367,065.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,474,800.00	319,230,799.38
210201	Тэтгэврийн даатгал	222,682,800.00	217,405,600.64
210202	Тэтгэмжийн даатгал	26,198,000.00	25,387,564.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,099,000.00	12,658,732.07
210204	Ажилгүйдлийн даатгал	13,099,000.00	12,643,023.21
210205	Эрүүл мэндийн даатгал	52,396,000.00	51,135,879.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,000,000.00	104,930,840.00
210302	Түлш, халаалт	63,500,000.00	63,499,840.00
210303	Цэвэр, бохир ус	13,000,000.00	12,931,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,555,400.00	53,555,290.97
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	53,555,400.00	53,555,290.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,929,100.00	170,711,126.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,659,600.00	148,441,626.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,130,600.00	158,130,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	158,130,600.00	158,130,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	134,123,600.00	134,123,550.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,485,028,500.00	3,484,959,340.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,485,028,500.00	3,484,959,340.00
122005	Орон нутгийн төсвөөс	3,485,028,500.00	3,484,959,340.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	71,794,685.14
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	75,458,006.44
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага		
610002	Төсвөөс гадуур байгууллага		

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	90	90
620001	Удирдах ажилтан	5	5
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57
620003	Үйлчлэх ажилтан	22	22
620004	Гэрээт ажилтан	6	6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 18.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1

Төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, тайлагнасны үндсэн дээр аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" үнэлгээ авсан нягтлан бодогч, нярав нарт үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон нь үр дүнгийн урамшуулалтай давхардан төсвийг үр ашиггүй зарцуулсан байх бөгөөд дээд шатны төсөв захирагчийн хууль, журамд нийцээгүй шийдвэрийг хэрэгжүүлснээр эрх бүхий албан тушаалтны нийтлэг үүргийг зөрчсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар хуулийн 37.1.6 дэх заалтуудыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

- **Илрүүлэлт-2**

Тайлант онд суралцагчдын дотуур байр, үдийн хоолны зардлыг нэг хүүхдээр баталсан норм нормативаас 14.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*) дахь заалт, Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолыг зөрчсөн ба иж бүрэн байх, ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнххаан сумын ЕБС-ийн захирлын 2024.05.22-ны өдрийн А/17 тоот тушаалаар байгууллагын нягтлан бодогч, няравт үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгогдсон бөгөөд энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үнэлэн улирал бүр олгосон мөнгөн урамшуулалтай давхацсан нь давхар урамшуулал олгох эрсдэл үүсгэж, төсвийн мөнгийг зохистой зарцуулахад сөрөг нөлөө үзүүлэхээр байна.	1	3,769.5			1	3,769.5		
Дотуур байр, үдийн хоолны батлагдсан норм, нормативыг баримтлаагүй нь төсвийн хэтрэлт, зарцуулалтын зохистой байдлыг алдагдуулж, санхүүгийн хяналт, хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.	1	14,591.7			1	14,591.7		
Дүн	2	18,361.2			2	18,361.2		